

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 7.1.22, 7.1.23, 7.1.24 дэх заалт:

“7.1.22.цэргийн анги, байгууллага офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчийг орон сууцаар хангаагүй бол орон сууц, гэр, байшин хөлслөх тухайн орон нутгийн түрээсийн төлбөрийг 12 хавтгай дөрвөлжин метрээр тооцож цэргийн анги, байгууллага олгох;

7.1.23.улсын хил болон алслагдсанд тооцох анги, байгууллагад таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагчид нэг удаагийн мөнгөн урамшууллыг тэдний сарын үндсэн цалингаас хилийн застав болон түүнтэй адилтгах салбарт 50 хувь, суурин бус газар байрладаг хилийн отряд, цэргийн анги, салбарт 35 хувь, нийслэл, улсын чанартай хотоос бусад суурин газарт байрладаг хилийн отряд, цэргийн анги, салбарт 25 хувиар бодож нэгтгэн таван жил тутамд олгох;

7.1.24.цэргийн тэтгэвэр тогтоолгосон бэлтгэл, чөлөөнд байгаа дээд офицерт урьд эрхэлж байсан албан тушаалын цэргийн цолны цалинг харьяалсан үндсэн байгууллага сар бүр олгох.”

2 дугаар зүйл.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:

9.5.Дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, суралцагчийн цалин хөлсний хэмжээ, нэмэгдэл олгох журмыг батлан хамгаалах, хил хамгаалалтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

3 дугаар зүйл.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалтын “сургалтын тэтгэлэг” гэснийг “цалин хөлс” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.